

ОҮИТБС-ын ажлын албанд

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын стандартын дагуу баталгаажуулалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг дор дурдсанаар хүргүүлж байна.

Нэг. Төсвийн бодлого, хуваарилалтын харьцаа: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцож, төсөвт тусгаж байна. Ингэхдээ хуульд заасны дагуу нэгдсэн төсвийн орлогын 3 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж буй гол нэр төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийг тухайн бүтээгдэхүүний олон жилийн дундаж үнийн түвшинд үндэслэн, тэнцвэржүүлсэн зарчмаар тооцож байна. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ болон тэнцвэржүүлсэн үнийн зөрүүгээс үүссэн орлогыг төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулан ажиллаж байна.

Түүнчлэн, Төсвийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу уул уурхайн салбарын гол орлогуудыг дараах байдлаар хуваарилж байна:

1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувийг Хүний хөгжил санд, 5 хувийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, үлдэх 25 хувийг Улсын төсөвт хуваарилж байна. Уул уурхайн салбар дахь орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, хүртэх өгөөжийг дээшлүүлэх зорилгоор УИХ 2015 оны 5 дугаар сард Төсвийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувийг Хүний хөгжил санд, 5 хувийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, үлдэх 30 хувийг (улсын чанартай тоомохон төслөөс бусад) Орон нутгийн хөгжлийн санд хуваарилахаар шийдвэрлэсэн;
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувийг Орон нутгийн хөгжлийн санд, үлдэх 50 хувийг улсын төсөвт хуваарилж байгаа бол газрын тосны тусгай зөвшөөрлийн 70 хувийг улсын төсөвт, 20 хувийг аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг тухайн сум, дүүргийн төсөвт хуваарилж байна;
3. Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх бол үлдэх 30 хувийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилж байна;
4. Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий орд газарт тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжийн төрийн өмчит ногдох ногдол ашгийн орлогыг хүний хөгжил санд төвлөрүүлж байна;
5. Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлж буй бусад татварыг Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хуульд заасны дагуу холбогдох төсөвт хуваарилж байна.

Хоёр. Тусгай сан, хөтөлбөрт эрдэс баялгийн салбараас олсон орлого хуваарилсан байдал:

Өнгөрсөн 2014 оны жилийн эцсийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын санд нийт 308.5 тэрбум төгрөг хуримтлагдсан байна. Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний үнэ тэнцвэржүүлсэн үнээс доош орсон тохиолдолд энэхүү хуримтлалаас улсын төсөвт шилжүүлэх болно. Түүнчлэн 2014 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 21.2 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилсан байна. Уул уурхайн орлогоос Хүний хөгжил санд нийт 426.9 тэрбум төгрөгийг хуваарилж, тус сангийн хөрөнгөөр хийгдэх зардлага санхүүжилтийг санхүүжүүлсэн байна.

Харин олборлох салбараас улс, орон нутгийн төсөвт төвлөрсөн бусад орлогыг тухайн жилийн төвийн хуульд заасны дагуу зарцуулсан болно. Дашрамд дурдахад уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт төвлөрсөн орлого нь бусад төрлийн татвар, төлбөр хураамжтай нийлж, нэгдсэн журмаар зарцуулагддаг тул зарцуулалтыг уул уурхайн болон уул уурхайн бус гэж тайлагнахад хүндрэлтэй байгааг анхаарна уу.

Гурав. Ирэх 2016-2018 оны эрдэс баялгийн салбараас орох орлогын төсөөлөл: Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл, олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн олборлолтын төлөвлөгөө зэрэг мэдээлэлд тулгуурлан эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогын тооцооллыг урьдчилсан байдлаар хийлээ. Ирэх 2016 онд олборлох салбараас нийт 1,132.4 тэрбум төгрөгийг олборлох салбараас төсөвт төвлөрүүлэхээр байгаа бол 2017 онд энэ орлого яльгүй буурч 1,041.8 тэрбум төгрөг болохоор байгаа бол 2018 онд дахин өсөж 1,154.3 тэрбум төгрөг төвлөрөхөөр байна.

Олборлох салбараас төсөвт төвлөрөх орлогын хэмжээ эрдэс бүтээгдэхүүний үнэ, томоохон төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтын хуваарь, үйлдвэрлэлийн хэмжээ зэргээс шалтгаалж ихээхэн хэлбэлзэхээр байгаа болно.

ТӨСВИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР